

Олгох хүрээ:

БНСУ-ын хуулийн дагуу гэрлэлтээ батлуулж, Солонгос эхнэр/нөхөртэйгээ хамт амьдрах зорилгоор БНСУ-д 91 хоногоос дээш хугацаагаар оршин суух гэж буй Монгол иргэн

БНСУ-ын Хилийн шалган нэвтрүүлэх тухай хуулийн Хэрэгжүүлэх журмын 9 дүгээр зүйл 5 (Гэр бүл болж хамт амьдрах зорилгоор виз олгох нөхцөл зэрэг)-д заасан нөхцлийг хангасан байх шаардлагатай.

Гэрлэлт цагаачлалын виз мэдүүлэхэд бүрдүүлэх материалын удирдамж
(Монгол улс дахь БНСУ-ын Элчин сайдын яам, 21. 1. 4.)

1. Үндсэн материал				
№	Бүрдүүлэх материал	Тайлбар	Олгох газар	Шалгах жагсаалт
1-1	Визний анкет (Виз мэдүүлгийн маягт)		Элчин сайдын яамны болон Солонгосын Виз мэдүүлэх төвийн вебсайт	<input type="checkbox"/>
1-2	Цээж зураг 1 % (3,5*4,5)	Анкет дээр наах		<input type="checkbox"/>
1-3	Виз мэдүүлэгч(Гадаад эхнэр/нөхөр)-ийн Гадаад паспорт эх хувь	Хүчинтэй хугацаа 6 сараас дээш байх	Иргэний бүртгэлийн ерөнхий газар	<input type="checkbox"/>
1-4	Виз мэдүүлэгчийн гадаад паспортын хуулбар 1 %	Хувийн мэдээлэлтэй нүүр хэсгийн хуулбар		<input type="checkbox"/>
1-5	Виз мэдүүлгийн хураамж	Визний хураамжаас чөлөөлөгдөнө. (СВМТ үйлчилгээний хураамжийг төлөх)		<input type="checkbox"/>
Бөглөх/бичих материал (Хамгийн чухал материал учир зөвхөн заасан маягтан дээр бүх хэсгийг орхигдуулахгүй бөглөнө.)				
1-6	Урилга	Солонгос эхнэр/нөхөр нь Солонгос хэлээр бичих	Элчин сайдын яамны болон Солонгосын Виз мэдүүлэх төвийн вебсайт	<input type="checkbox"/>
1-7	Батлан даалтын бичиг			<input type="checkbox"/>
1-8	Гадаад эхнэр/нөхөр-ийн гэрлэлтийн байдлын талаарх дэлгэрэнгүй анкет	Гадаад эхнэр/нөхөр нь Англи эсвэл Солонгос хэлээр бичих		<input type="checkbox"/>
Солонгос эхнэр/нөхөр-ийн бүрдүүлэх үндсэн материал				
1-9	Солонгос эхнэр/нөхөр-ийн гадаад паспортын хуулбар 1 %	Хувийн мэдээлэлтэй нүүр хэсгийн хуулбар		<input type="checkbox"/>
1-10	Үндсэн мэдээллийн лавлагаа (дэлгэрэнгүй)	Солонгос хэл дээр материал тус бүр 1 хувь байх. Олгосон өдрөөс эхлээд 3 сарын дотор хүчинтэй байна.	Иргэний бүртгэлийн ерөнхий газар эсвэл Min-won24 вебсайт	<input type="checkbox"/>
1-11	Гэрлэлтийн лавлагаа (дэлгэрэнгүй)			<input type="checkbox"/>
1-12	Ам бүлийн тодорхойлолт (дэлгэрэнгүй)			<input type="checkbox"/>
1-13	Иргэний бүртгэлийн лавлагаа эх хувь			<input type="checkbox"/>

1-14	Гадаад иргэнтэй гэр бүл болж буй иргэдэд зориулсан сургалтын гэрчилгээ	Чөлөөлөгдөх иргэд (#1 лавлаж үзэх) бүрдүүлэх шаардлагагүй	Гадаадын Иргэн, Харьяатын Газар	<input type="checkbox"/>
1-15	Эрүүл мэндийн магадалгаа эх хувь	#2 лавлаж үзэх	Эмнэлэг / Эрүүл мэндийн төв	<input type="checkbox"/>
Гадаад эхнэр/нөхөр-ийн бүрдүүлэх үндсэн материал				
1-16	Гэрлэлтийн лавлагаа эх хувь		Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар эсвэл түц машин	<input type="checkbox"/>
1-17	Цагдаагийн газрын тодорхойлолт эх хувь	Олгосон өдрөөс эхлээд 3 сарын дотор хүчинтэй байх, #3 лавлаж үзэх	Цагдаагийн Ерөнхий Газар	<input type="checkbox"/>
1-18	Эрүүл мэндийн үзлэгт орсон магадалгаа эх хувь	#4 лавлаж үзэх	Нэгдсэн эмнэлэг / Томоохон эрүүл мэндийн төв	<input type="checkbox"/>
1-19	Монгол улсад тусгайлан заасан материал	Монгол улсад хамаарахгүй		

*** #1 (Гадаад иргэдтэй гэрлэж буй иргэдэд зориулсан сургалтаас чөлөөлөгдөх иргэд)**

1. Гадаад эхнэр/нөхөр-ийн харьяа улсад эсвэл 3 дахч улсад 6 сараас дээш оршин суусан, сурсан, томиллоор ажилласан зэргээс хамааран урт хугацааны визээр байнгын оршин суунгаа танилцаж дотноссон нь үнэн болохоо нотолсон хүн.
2. Гадаад эхнэр/нөхөр нь Солонгос улсад гадаад иргэний бүртгэл хийлгэн 91 хоногоос дээш хугацаагаар хууль ёсны дагуу оршин суунгаа Солонгос эхнэр/нөхөртэйгөө танилцаж дотноссон нь үнэн болохоо нотолсон хүн.
3. Жирэмсэн(20 долоо хоногоос дээш), хүүхэд төрүүлсэн зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантай гэж үзсэн хүн

***#2 (Солонгос эхнэр/нөхөр-ийн эрүүл мэндийн магадалгаа)** Эмнэлэгтэй дүйцэхүйц зэрэглэл бүхий эрүүл мэндийн байгууллага эсвэл эрүүл мэндийн төвд, төрийн албан хаагчийн эрүүл мэндийн шинжилгээний журамд заасан шинжилгээний төрлүүдэд багтсан маягтын дагуу бүрдүүлнэ. Виз мэдүүлсэн өдрөөс 6 сарын дотор авсан байна. Гадаад иргэнтэй гэрлэж буй иргэдэд зориулсан сургалтад суухаас чөлөөлөгдсөн бол энэ материалаас давхар чөлөөлөгдөнө.

*** #3 (Гадаад эхнэр/нөхөр-ийн цагдаагийн газрын тодорхойлолт)** Солонгос эхнэр/нөхөр нь гадаад иргэнтэй гэрлэж буй иргэдэд зориулсан сургалтанд суухаас чөлөөлөгдсөн бол энэ материалаас давхар чөлөөлөгдөнө.

*** #4 (Гадаад эхнэр/нөхөр-ийн эрүүл мэндийн магадалгаа)** Виз мэдүүлсэн өдрөөс 6 сарын дотор авсан байна. Эмнэлгийн нэр, хаяг, холбогдох дугаар, эмчийн гарын үсэг зэрэг тэмдэглэгдсэн байх шаардлагатай ба компьютераар шивэгдсэн байна(Зайлшгүй тохиолдолд гараар бичихийг зөвшөөрнө). Эрүүл мэндийн шинжилгээ нь жишээ татсан төрлөөс гадна сүрьеэ/ДОХ/БЗХӨ/сэтгэцийн өвчин байгаа эсэх мэдээлэл зайлшгүй тэмдэглэгдсэн байна. Мөн аймгийн нэгдсэн эмнэлэг эсвэл үүнтэй дүйцэх хэмжээний томоохон эмнэлгээс авсан магадалгааг хүлээн зөвшөөрнө. Солонгос эхнэр/нөхөр нь гадаад иргэнтэй гэрлэж буй иргэдэд зориулсан сургалтанд суухаас чөлөөлөгдсөн бол гадаад эхнэр/ нөхөр энэ материалаас давхар чөлөөлөгдөнө. Зөвхөн сүрьеэний шинжилгээний магадалгааг зайлшгүй өгөх шаардлагатай (Жирэмсний улмаас сүрьеэний шинжилгээ өгөхөд хүндрэлтэй байгаа тохиолдолд тусад нь тэмдэглэн мэдэгдэх шаардлагатай.)

2. Солонгос эхнэр/нөхөр-ийн орлого нотлох бичиг баримт

* Анхааруулга: Орлого нотлох бичиг баримт нь доор дурдсан бүх материалыг бүрдүүлэх шаардлагагүй (зөвхөн “зайлшгүй шаардлагатай үндсэн материал”-ийг зайлшгүй бүрдүүлж өгнө). Уригч нь орлогын нөхцөлийг хангаж байгаагаа нотлохын тулд бүрдүүлэх материалаа өөрөө сонголтоор бүрдүүлнэ.

* Орлого нотлох материалаас чөлөөлөгдөж буй тохиолдолд доорх материалыг бүрдүүлэх шаардлагагүй. (#1 лавлаж үзэх)

№	Бүрдүүлэх материал	Тайлбар	Олгох газар	Шалгах жагсаалт
2-1	Зайлшгүй шаардлагатай үндсэн материал	Орлогын мэдүүлгийн тодорхойлолт эх хувь	Татварын Ерөнхий газар болон вебсайтаас авах	<input type="checkbox"/>
2-2		Зээл төлбөр мэдээллийн лавлагаа 1 %	Солонгос зээлийн мэдээллийн газрын вебсайтаас авах	<input type="checkbox"/>
2-3	Ажил эрхэлдэг тохиолдолд	Орлогын албан татвар төлсөн баримт	Одоогийн Ажлын газар эсвэл өмнөх ажлын газраасаа авах	<input type="checkbox"/>
2-4		Ажлын газрын тодорхойлолт		<input type="checkbox"/>
2-5		Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар		<input type="checkbox"/>
2-6		Орлого нотлох бичиг баримт (Сонголтоор)	Дээрх материалуудаар орлогоо нотлох боломжгүй тохиолдолд нэмж бөглөх боломжтой материал	<input type="checkbox"/>
2-7	Бизнес эрхэлдэг тохиолдолд (#2, #3 лавлаж үзэх)	Аж ахуй нэгжийн гэрчилгээний тодорхойлолт юмуу Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар	Газар тариалан, ан агнуур, загас агнуурын, аж үйлдвэрийн ажилчдад үл хамаарна.	<input type="checkbox"/>
2-8		Орлого нотлох бичиг баримт (Сонголтоор)	Орлогын мэдүүлгийн тодорхойлолтон дээрх дүн нь орлого нотлох шаардлага хангахгүй байх тохиолдолд үүнийг нөхөх боломжтой материал	<input type="checkbox"/>
2-9	Бусад орлогоо нотлох тохиолдолд	Орлого нотлох бичиг баримт	(Жишээ) Түрээсийн орлого: Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа, түрээсийн гэрээний хуулбар, Хүүний орлого : Дансны хуулга гэх мэт	<input type="checkbox"/>
2-10	Эд хөрөнгөөр орлогоо нотолж буй тохиолдолд	Хадгаламж, даатгал, үнэт цаас, бонд,	1 сая воноос дээш, 6 сараас дээш хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд хүлээн зөвшөөрнө. Үл хөдлөх хөрөнгийн хувьд үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн лавлагаа болон зах зээлийн үнэлгээний хуудас өгөх	<input type="checkbox"/>
2-11		Үл хөдлөх хөрөнгө		<input type="checkbox"/>

2-12	Гэр бүлийн орлого эсвэл өмч хөрөнгө ашиглаж буй тохиолдолд	Гадаад эхнэр/нөхөр, уригч талын гэр бүлийн орлогын байдлын мэдүүлгийн бичиг	Элчин сайдын яам эсвэл НИКОРЕА вебсайт дахь маягтын дагуу бичнэ. (#4 лавлаж үзэх)	<input type="checkbox"/>
		Нотлох бичиг баримт	Ажил эрхэлдэг, бизнес эрхэлдэг, бусад орлого мөн өмч хөрөнгө зэргээс хамааран дээрх дурдсан орлого нотлох материал дээр үндэслэн материалаа бүрдүүлнэ.	<input type="checkbox"/>

***#1(Орлого нотлох шаардлагаас чөлөөлөгдөх)** 1. Хосуудын дундаас төрсөн хүүхэдтэй юмуу жирэмсний 20 долоо хоног өнгөрсөн тохиолдолд. 2. Хосууд виз мэдүүлсэн өдрөөс эхлэн 1 жилээс илүү хугацаанд гадаадад хамт амьдарч, Солонгос дахь орлого сүүлийн 1 жил байхгүй тохиолдолд. 3. Өмнө нь гадаад эхнэр/нөхөр нь гэрлэлт цагаачлал (F-6) визээр Солонгос улсад оршин сууж байсан тохиолдолд (Жич, эхнэр/нөхөр өөрчлөгдсөн эсвэл виз мэдүүлэгч өөрөө хэдий ч гэрлэлт цуцлагдаж байсан тохиолдолд хамааралгүй). 1. дугаарт хамаарагдах иргэн нь хүүхдийн нэр дээрх гэр бүлийн лавлагаа (Гэрлэлт бүртгүүлэхээс өмнө төрөөд, иргэний харьяалал аваагүй байгаа бол төрсний бүртгэлийн лавлагаа өгөх) эсвэл жирэмсний бичиг 2. дугаарт хамаарагдах иргэн нь хамтран амьдарч байснаа нотлох материал бүрдүүлж өгнө.

*** #2 (Бизнесийн орлоготой холбоотой анхаарах зүйл 1)** Бизнесийн орлогыг журмын дагуу татварын ерөнхий газраас олгодог орлогын мэдүүлгийн тодорхойлолтон дээр тэмдэглэгдсэн мөнгөн дүнгийн дагуу дүгнэлт хийнэ. Хэрвээ бодит орлого нь орлогын мэдүүлгийн тодорхойлолтон дээрх мөнгөн дүнгээс их байвал орлогыг дутуу үнэлэн тайлагнасанд тооцож болох ба татварын албанд шинэчилсэн тайлангаа гарган өгч засварласны дараа засварлагдсан орлогын мэдүүлгийн тодорхойлолтыг өгнө үү.

*** #3 (Бизнесийн орлоготой холбоотой анхаарах зүйл 2)** Журмын дагуу виз мэдүүлсэн өдрөөс тооцон 1 жилийн өмнөх орлоготой холбогдолтой бичиг баримт бүрдүүлж өгөх шаардлагатай боловч бизнесийн орлогын хувьд дараа жилийн 5 сард орлогын тайлан хийгддэг онцлогтой байдаг. Үүнийг харгалзаж үзэн орлогын мэдүүлгийн тодорхойлолт дээрх хамгийн сүүлийн жилийн орлого нь заасан орлогын шаардлагыг хангаж тухайн бизнесээ үргэлжлүүлэн тасралтгүй эрхэлж байгаа тохиолдолд виз мэдүүлсэн өдрөөс эхэлж тооцохгүйгээр сүүлийн 1 жилийн орлогыг хамгийн сүүлийн мэдүүлгээр тооцох боломжтой. (Зарим тохиолдолд бодит байдлын судалгаа хийгдэх боломжтой.)

*** #4 (Орлогын нөхцөл дээр нэмэгдэх боломжтой гэр бүлийн гишүүдийн хүрээ)** Солонгос эхнэр/нөхөр-ийн иргэний бүртгэлийн лавлагаан дээр өрхийн бүртгэлтэй шууд хамаарал бүхий гэр бүл (эцэг эх, эмээ өвөө, хүүхэд гэх мэт) мөн уригдагч тал болох гэрлэлтээр цагаачлагч нь орлогын нөхцөл дээр нэмэгдэх боломжтой. Шууд хамаарал бүхий гэр бүл хэдий ч иргэний бүртгэлийн лавлагаан дээр өрхийн бүртгэлгүй бол орлогын нөхцөл дээр нэмэгдэх боломжгүй бөгөөд ах, эгч, дүү нар нь шууд хамаарал бүхий гэр бүл биш учир орлогын нөхцөл дээр нэмэгдэх боломжгүй.

*** (Жич) 2021 оны орлогын тогтсон хэмжүүр:** Уригч талын сүүлийн 1 жилийн орлого(татварын өмнөх) нь доорх хүснэгтэд заасан мөнгөн дүнгээс дээш байх шаардлагатай.

Ангилал	2 ам бүл	Зам бүл	4ам бүл	5ам бүл	6ам бүл	7ам бүл	8 ам бүлээс дээш
Орлогын тогтсон хэмжээ (Вон)	18,528,474	23,903,700	29,257,740	34,544,238	39,771,618	44,983,188	7 ам бүлийн орлого дээр 1 хүн тус бүрийн 5,211,570вон нэмэгдэнэ.

3. Гадаад эхнэр/нөхрийн хэлний түвшинг нотлох материал

* Анхааруулга: Доор дурдсан материалуудаас нэгийг нь сонгож өгнө үү. Хэлний түвшинг нотлох материалаас чөлөөлөгдөх иргэн биш хэдий ч доорх материалуудаас нэгийг нь ч өгөөгүй тохиолдолд элчин сайдын яамнаас авах шалгалтын дүнгээс хамааран шаардлага хангаж байгаа эсэхийг шийднэ.

* Хэлний түвшинг нотлох материалаас чөлөөлөгдөх иргэд доорх бичиг баримтыг бүрдүүлж өгөх шаардлагагүй. (Доорх #1 лавлаж үзэх)

№	Бүрдүүлэх материал	Тайлбар	Олгох газар	Шалгах жагсаалт
3-1	Солонгос хэл	Сэжон Хагданд суралцан төгссөн сертификат	Солонгос хэлний анхан шатны сургалтыг 120 цагаас дээш дүүргэсэн байх(2021 оны 1 сарын 4-өөс хойш олгогдсон тохиолдолд хүлээн зөвшөөрнө.)	<input type="checkbox"/>
3-2		Солонгос хэлний түвшинг тогтоох шалгалт(ТОPIK)-ын дүнгийн хуудас	ТОPIK 1 ба түүнээс дээш түвшинг хүлээн зөвшөөрнө	<input type="checkbox"/>
3-3		Нийгэмд нэгтгэх хөтөлбөр(KIIP)-т суралцан төгссөн сертификат	2 ба түүнээс дээш түвшинг хүлээн зөвшөөрнө.	<input type="checkbox"/>
3-4		Зааж тогтоосон боловсролын байгууллагад суралцан төгссөн сертификат	Монгол улсад хамаарахгүй	<input type="checkbox"/>
3-5		Солонгос хэлтэй холбогдолтой мэргэжил эзэмшсэн бакалавр болон магистерийн төгсөлтийн диплом		<input type="checkbox"/>
3-6		Гадаадын иргэншилтэй Солонгос үндэстэнг нотлох бичиг баримт	Шаардлагатай бол Солонгос хэлээр ярих чадварыг шалгана.	<input type="checkbox"/>
3-7		Гадаад эхнэр/нөхөр нь Солонгос улсад 1 жилээс дээш хугацаанд оршин сууж байсныг нотлох бичиг баримт	Хилээр орж гарсан нь үнэн болох тодорхойлолт эсвэл гараар бичсэн мэдүүлэг (Заасан маягт байхгүй)	<input type="checkbox"/>
3-8	Гадаад эхнэр/нөхөр-ийн орны хэл	Солонгос эхнэр/нөхөр нь гадаад эхнэр/нөхөр-ийнхөө орны албан ёсны хэлээр ярьдаг улсад 1 жилээс дээш хугацаанд байнгын оршин суусан тухай нотлох бичиг баримт	Тус улсын хилээр орж гарсан нь үнэн болох тодорхойлолт эсвэл гараар бичсэн мэдүүлэг (Заасан маягт байхгүй)	<input type="checkbox"/>
3-9		Солонгос эхнэр/нөхөр нь гадаад эхнэр/нөхөр-ийнхөө орны албан ёсны хэлээр ярьдаг улсаас гаралтай, иргэншлээ сольсон тухай нотлох бичиг баримт		<input type="checkbox"/>
3-10	Бусад хэл	Солонгос эхнэр/нөхөр болон гадаад эхнэр/нөхөр нь тус хэлийг албан ёсоор хэрэглэдэг улсад 1 жилээс дээш хугацаанд байнгын оршин суусан тухай нотлох бичиг баримт	Тус улсын хилээр орж гарсан нь үнэн болох тодорхойлолт эсвэл гараар бичсэн мэдүүлэг (Заасан маягт байхгүй)	<input type="checkbox"/>
3-11	Нийтлэг	Хэлний түвшинг нотлох бусад бичиг баримт	Доорх #2 лавлаж үзэх	<input type="checkbox"/>

*#1(Хэлний түвшинг нотлох материалаас чөлөөлөх) 1. Хосуудын дундаас төрсөн хүүхэдтэй юмуу жирэмсний 20 долоо хоног өнгөрсөн тохиолдолд. 2. Өмнө нь гадаад эхнэр/нөхөр нь гэрлэлт цагаачлал (F-6) визээр Солонгос улсад оршин сууж байсан тохиолдолд (Жич, эхнэр/нөхөр өөрчлөгдсөн эсвэл виз мэдүүлэгч өөрөө хэдий ч гэрлэлт цуцлагдаж байсан тохиолдолд хамааралгүй) хэлний түвшинг нотлох материалаас чөлөөлөгдөнө.

*#2(Хэлний түвшинг нотлох бусад бичиг баримт) Солонгос эхнэр/нөхөр эсвэл гадаад эхнэр/нөхөр нь 1. Тодорхой түвшинээс дээш, тухайн харилцаж буй хэлнийхээ түвшинг тогтоох шалгалтын дүнг баталсан онооны сертификат өгөх тохиолдолд. 2. Тухайн хэлний мэдлэгийг ЭСЯ-аас ярилцлага авах ба тэнцсэн тохиолдолд хэлний түвшинг нотлох шаардлага хангаж байна гэж үзнэ.

4. Солонгос эхнэр/нөхөр-ийн амьдрах байрны нөхцөлийг нотлох бичиг баримт

* Анхааруулга: Амьдрах байрны хаяг нь иргэний бүртгэлийн лавлагаан (1-13) дээрх хаягтай адил байна.

№	Бүрдүүлэх материал	Тайлбар	Олгох газар	Шалгах жагсаалт
4-1	Өөрийн эзэмшил	Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн лавлагаа		<input type="checkbox"/>
4-2	Түрээсийн байр	Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн лавлагаа		<input type="checkbox"/>
4-3		Түрээсийн гэрээний хуулбар 1 %		<input type="checkbox"/>

*#1(Амьдрах байрны нөхцөлийг нотлох) Оршин суух байр нь Солонгос эхнэр/нөхөр эсвэл Солонгос эхнэр/нөхөр-ийн шууд хамаарал бүхий гэр бүл, ах, эгч, дүүгийн нэр дээр эзэмшсэн болон түрээсэлсэн газар байх шаардлагатай. Гуравдагч этгээдийн нэр дээр эзэмшлийн бүртгэлтэй , түрээсэлдэг байх тохиолдолд журмын дагуу амьдрах нөхцөлийг хангаагүйд тооцох бөгөөд компаниас хангасан байр зэрэг нийгмийн ерөнхий ухагдахуунаар хүлээн зөвшөөрөгдсөн газар байх тохиолдолд онцгой нөхцөлөөр хүлээн зөвшөөрнө.

5. Танилцаж дотноссон тухайгаа нотлох материал

№	Бүрдүүлэх материал	Тайлбар	Олгох газар	Шалгах жагсаалт
5-1	Зайлшгүй шаардлагатай үндсэн материал	Танилцан дотноссон талаарх тайлбар, гэрлэлтийн үнэн бодит байдлыг нотлох материал	Танилцаж дотноссон зураг, гэр бүлийн зураг, SNS харилцааны түүх зэргийг А4 цаасан дээр хэвлэн бэлдэж өгнө. (5 хуудасанд багтаах)	<input type="checkbox"/>
5-2	Гэрлэлт зуучлалын компаниар дамжуулан танилцсан тохиолдолд	Гэрлэлт зуучлалын компанийн гэрчилгээний хуулбар	Материал бүрдүүлж өгөх боломжгүй тохиолдолд тайлбар бичиг өгөх (Доорх #1-т хамаарагдвал материалаас чөлөөлөгдөнө.)	<input type="checkbox"/>
		Баталгаат даатгалын сертификатын хуулбар		<input type="checkbox"/>
		Гэрээний хуулбар		<input type="checkbox"/>
5-3	Танилаараа дамжуулж танилцсан тохиолдолд	Танилцуулсан хүний иргэний үнэмлэхний хуулбар		<input type="checkbox"/>

* #1 (Танилцаж дотноссон тухай нотлох материалаас чөлөөлөх) 1. Хосуудын дундаас төрсөн хүүхэдтэй тохиолдолд 2. Өмнө нь гадаад эхнэр/нөхөр нь гэрлэлт цагаачлал(F-6) визээр Солонгос улсад оршин сууж байсан тохиолдолд (Жич, эхнэр/нөхөр өөрчлөгдсөн эсвэл виз мэдүүлэгч өөрөө хэдий ч гэрлэлт цуцлагдаж байсан тохиолдолд хамааралгүй)

[Бичиг баримтаас хөнгөвчилсөн жишээ тус бүр дээр бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт]

1. Хосуудын дундаас төрсөн хүүхэдтэй тохиолдолд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт

Ангилал	Бичиг баримтын жагсаалт	
Үндсэн материал	Визний анкет, цээж зураг, виз мэдүүлэгчийн (Гадаад эхнэр/нөхөр) гадаад паспорт эх хувь, хуулбар 1%, виз мэдүүлгийн хураамж	<input type="checkbox"/>
	Гадаад эхнэр/нөхөр-өө урьж буй урилга, батлан даалтын бичиг, гадаад эхнэр/нөхөр-ийн гэрлэлтийн байдлын талаарх дэлгэрэнгүй анкет	<input type="checkbox"/>
	(Солонгос эхнэр/нөхөр)-ийн гадаад паспортын хуулбар 1 %, Үндсэн мэдээллийн лавлагаа (дэлгэрэнгүй) 1%, Гэрлэлт бүртгэлийн лавлагаа(дэлгэрэнгүй) 1%, Ам бүлийн тодорхойлолт (дэлгэрэнгүй) 1%, Хүүхдийн нэр дээрх гэр бүлийн лавлагаа(дэлгэрэнгүй) 1% (Боломжгүй тохиолдолд төрсний гэрчилгээ), Иргэний бүртгэлийн лавлагаа (Солонгос хэл дээр) 1 %	<input type="checkbox"/>
	(Гадаад эхнэр/нөхөр) Өөрийн улсын гэрлэлт бүртгэлийн лавлагаа 1 %, Сүрьеэгийн шинжилгээний эмчийн магадалгаа (Монгол улс сүрьеэгийн өндөр эрсдэлтэй орон учир зайлшгүй өгөх шаардлагатай) 1 %, Тухайн улсад тусгайлан хамаарах бусад бичиг баримт	<input type="checkbox"/>
Амьдрах байрны нөхцөлийг нотлох	Өөрийн эзэмшил: Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн лавлагаа, Түрээсийн байр: Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн лавлагаа, Түрээсийн гэрээний хуулбар 1%	<input type="checkbox"/>
Танилцаж дотноссон тухайгаа нотлох	Нийтлэг зайлшгүй шаардлагатай үндсэн материал	<input type="checkbox"/>

2. Гадаад иргэнтэй гэр бүл болж буй иргэдэд зориулсан сургалтаас чөлөөлөгдөх иргэн (Жирэмсэн г.м)-ий бүрдүүлэх жагсаалт

Ангилал	Бичиг баримтын жагсаалт	
Үндсэн материал	Визний анкет, цээж зураг, виз мэдүүлэгчийн (Гадаад эхнэр/нөхөр) гадаад паспортын эх хувь болон хуулбар 1 %, виз мэдүүлгийн хураамж	<input type="checkbox"/>
	Гадаад эхнэр/нөхөр-өө урьж буй урилга, батлан даалтын бичиг, гадаад эхнэр/нөхөр-ийн гэрлэлтийн байдлын талаарх дэлгэрэнгүй анкет	<input type="checkbox"/>
	(Солонгос эхнэр/нөхөр)-ийн гадаад паспортын хуулбар 1 %, үндсэн мэдээллийн лавлагаа (дэлгэрэнгүй) 1 %, гэрлэлт бүртгэлийн лавлагаа (дэлгэрэнгүй) 1 %, ам бүлийн тодорхойлолт (дэлгэрэнгүй) 1 %, иргэний бүртгэлийн лавлагаа (Солонгос хэл дээр) 1 %	<input type="checkbox"/>
	(Гадаад эхнэр/нөхөр) Өөрийн улсын гэрлэлт бүртгэлийн лавлагаа 1 %, Сүрьеэгийн шинжилгээний эмчийн магадалгаа (Монгол улс сүрьеэгийн өндөр эрсдэлтэй орон учир зайлшгүй өгөх шаардлагатай) 1 %, Тухайн улсад тусгайлан хамаарах бусад бичиг баримт	<input type="checkbox"/>
Орлого нотлох	Дэлгэрэнгүйг дээрх орлого нотлох хэсгээс лавлаж үзэх.	<input type="checkbox"/>
Солонгос хэлний түвшинг нотлох	Дэлгэрэнгүйг дээрх Солонгос хэлний түвшин нотлох хэсгээс лавлаж үзэх.	<input type="checkbox"/>

Амьдрах байрны нөхцөлийг нотлох	Өөрийн эзэмшил: Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн лавлагаа, Түрээсийн байр: Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн лавлагаа, Түрээсийн гэрээний хуулбар 1%	<input type="checkbox"/>
Танилцаж дотноссон тухайгаа нотлох	Нийтлэг зайлшгүй шаардлагатай үндсэн материал / Танилцан дотноссон талаарх тайлбар тус бүрийн материал	<input type="checkbox"/>

3. Өмнө нь гэрлэлт цагаачлал (F-6) визээр оршин сууж байсан тохиолдолд

Ангилал	Бичиг баримтын жагсаалт	
Үндсэн материал	Визний анкет, цээж зураг, виз мэдүүлэгчийн (Гадаад эхнэр/нөхөр) гадаад паспорт эх хувь болон хуулбар 1%, виз мэдүүлгийн хураамж	<input type="checkbox"/>
	Гадаад эхнэр/нөхөр-өө урьж буй урилга, батлан даалтын бичиг	<input type="checkbox"/>
	(Солонгос эхнэр/нөхөр)-ийн гадаад паспортын хуулбар 1 %, үндсэн мэдээллийн лавлагаа (дэлгэрэнгүй) 1 %, гэрлэлт бүртгэлийн лавлагаа (дэлгэрэнгүй) 1 %, ам бүлийн тодорхойлолт (дэлгэрэнгүй) 1 %, иргэний бүртгэлийн лавлагаа (Солонгос хэл дээр) 1 %	<input type="checkbox"/>
	(Гадаад эхнэр/нөхөр) Өөрийн улсын гэрлэлт бүртгэлийн лавлагаа 1 %, Сүрьеэгийн шинжилгээний эмчийн магадалгаа (Монгол улс сүрьеэгийн өндөр эрсдэлтэй орон учир зайлшгүй өгөх шаардлагатай) 1 %, Тухайн улсад тусгайлан хамаарах бусад бичиг баримт	<input type="checkbox"/>
Амьдрах байрны нөхцөлийг нотлох	Өөрийн эзэмшил: Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн лавлагаа, Түрээсийн байр: Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн лавлагаа, Түрээсийн гэрээний хуулбар 1%	<input type="checkbox"/>
Танилцаж дотноссон тухайгаа нотлох	Нийтлэг зайлшгүй шаардлагатай үндсэн материал	<input type="checkbox"/>

* Жич, эхнэр/нөхөр өөрчлөгдсөн эсвэл виз мэдүүлэгч өөрөө хэдий ч гэрлэлт цуцлагдаж байсан тохиолдолд хамааралгүй

[Анхаарах зүйлс]

1. Дээрх бүрдүүлэх материалын жагсаалт нь 2021.1.4-ний өдрийн байдлаар бичигдсэн болно. Визний материалын журмын өөрчлөлтөөс хамааран урьдчилж мэдэгдэлгүйгээр өөрчлөгдөж болох тул виз мэдүүлэхээс өмнө шаардлагатай баримт бичгийн жагсаалтанд өөрчлөлт орсон эсэхийг Элчин сайдын яамны вебсайтаас шалгана уу.

2. Бүрдүүлэх бичиг баримт орхигдсон тохиолдолд виз мэдүүлэг авахаас татгалзах боломжтой тул бүрдүүлэх материалын жагсаалтын дагуу бүрдүүлнэ үү. Хурдан шуурхай виз мэдүүлэхийн тулд **материалыг дарааллын дагуу цэгцэлж өгнө** үү. Дээрх бүрдүүлэх материалын жагсаалт нь гэрлэлт цагаачлалын виз мэдүүлэхэд бүрдүүлэх үндсэн материалууд юм. Виз мэдүүлэх эсвэл визний материал шалгах явцад шаардлагатай гэж үзвэл нэмэлт бичиг баримт шаардаж болно.

3. Визний материалаа өгөхдөө виз мэдүүлэгч (Монгол эхнэр/нөхөр) нь Солонгосын Виз мэдүүлэх төв (KVAS) дээр өөрийн биеэр очиж визээ мэдүүлэх шаардлагатай ба, **шуудангаар материал хүлээж авахгүй**. Материал хүлээж авах цаг: 08:30 – 16:30

- * Виз мэдүүлэх төв(KVAC)-ийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 14230, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Энгельсийн гудамж-2, Шинэ Сонголт барилга, 8 давхар
- * Утас: +976-7766-8888
- * И-мэйл: kvacmninfo@iom.int
- * Вебсайт: www.visaforkorea.mn

4. Визний материал шалгах хугацаа нь ажлын 20 хоног бөгөөд, бичиг баримт лавлах хугацаа, нэмэлт материал шаардах, ярилцлага, бодит байдлын судалгаа зэрэг шалтгаанаар уртсах боломжтой. Шалгах хугацаа хэвийн явагдах тохиолдолд заасан хуваарийн дагуу визний хариу гарна. Виз олгосон ч тухайн улсаас хамааран хилээр гарахад тусгай журам үйлчилэх боломжтой байдаг тул үүнийг анхаарна уу. Түүнчлэн гэрлэлт цагаачлалын виз авсан хүн онгоцны тийээ нэг талдаа авах боломжтой байдаг.

5. Виз мэдүүлэхдээ хуурамч мэдээлэл өгөх эсвэл хуурамч бичиг баримт бүрдүүлж өгсөн тохиолдолд виз мэдүүлгээс татгалзуулахаас гадна, гадаад эхнэр/нөхөр-ийг 5 жилээс дээш хугацаагаар Солонгос улсад нэвтрэхийг хориглох, гадаад эхнэр/нөхөр нь Солонгос улсад нэвтэрсний дараа энэхүү үнэн нь илэрвэл хилээр албадан гаргах боломжтой. Үүнээс гадна Хилийн шалган нэвтрүүлэх тухай хуулийн Хэрэгжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 2, мөн энэхүү хуулийн 94 дугаар зүйлд заасны дагуу 3-аас доош жилийн хорих ял эсвэл 20 сая воноос доош хэмжээний мөнгөн торгууль тавигдах боломжтой.

6. Бүх бичиг баримт нь дүрэм журмын дагуу эх хувиар нь өгөх ба Англи, Солонгос хэлнээс бусад хэл дээрх материалыг орчуулсан хувьтай хамт өгөх шаардлагатай. (Элчин Сайдын яамнаас шаардлагатай үед нотариат хийлгэх хүсэлт тавих боломжтой.)

7. Монголд түрүүлж гэрлэлтээ батлуулсан тохиолдолд Монгол эхнэр/нөхөр-ийн гэрлэлтийн лавлагаан дээрх батлуулсан өдөр нь Солонгос гэрлэлтийн лавлагаан дээрх батлуулсан өдөртэй ижил байгаа эсэхийг шалгана уу. Улс бүрт бичиг баримтын бүртгэл хийгдэх арга барил өөр байдаг учир Солонгос эхнэр/нөхөр нь тус улсад оршин суугаагүй өдрөөр гэрлэлтийн баталгаа хийгдсэн бодит жишээ үе үе үүсэж байгаа тул анхааралтай хандана уу.

8. Виз мэдүүлэгтэй холбогдолтой мэдээллийг Виз мэдүүлэх төв (KVAC)-өөс лавлах ба бусад мэдээллийг БНСУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны консулын хэлтсийн и-мэйл kormg2@mofa.go.kr , утас +976-7007-1030 дугаарт холбоо барина уу. (Факс +976-7007-1031)